

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК						
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ОРОН СУУЦ ӨМЧЛӨГЧ ЭЗЭМШИГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр			Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай			2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм			<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог			Нэр			
		Балсан			Баярмагнай			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>								
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх							
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>								
9	Даатгалын зүйл	Даатгуулагч орон сууц ашиглах явцдаа гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн өмнө хүлээх хариуцлага						
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Галын эрсдэл 2. Ус алдалт 3. Цахилгаан эрчим хүчний хэвийн бус хэлбэлзэл, хэт ачаалал, богино холболтоос үүдэн электрон болон цахилгаан хэрэгсэлд учруулсан хохирол						
	Даатгалын нэмэлт эрсдэл	-						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.8-1.5%						

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ**

1. Даатгагч Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.5 дугаар зүйлд заасан үндэслэл үүссэн;
2. Орон сууц доторх тавилга, эд хогшил буюу зураг, бүдүүвч зураг, загвар, уран зураг, урлагийн эртний бүтээл, хөгжмийн зэмсэг, бэлэн мөнгө, цуглуулга;
3. Эд хөрөнгийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, зэврэлт, исэлдэл ууршилт, үйлдвэрийн гэмтэл зэрэг тухайн хөрөнгө, бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол, гэмтэл, газар хөдлөлт;
4. Даатгалын зүйлийн баталгаат хугацааны аливаа эвдрэл гэмтэл, хохирол;
5. Даатгалын эрсдэлээс үл хамаарсан орон сууцанд хийгдэх засварын ажлаас учирсан хохирол;

6. Механик гэмтэл, эвдрэл, хагарал мөн өмнө нь эвдэрч байсан, бүрэн засагдаагүй, өө сэвтэй шил эсвэл бусад хэврэг материалын гэмтэл;
7. Үйлдвэрлэлийн дефекттэй холбоотой үйл ажиллагааны болон ур хийцийн алдаа, алдаатай зураг төсөл, зөвшөөрөлгүй шинэчлэн боловсруулсан барилгын зураг төсөл;
8. Шалгаагүй ба баталгаажуулаагүй технологи ашигласан, шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
9. Хүний үйл ажиллагаанаас хамааралтай хөрсний нуралт, цөмрөлт;
10. Дайн, зэвсэгт бослого, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, йжил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр зэргийн улмаас үүссэн нөхцөл байдал, улс төрийн тэмцэлд оролцсоноос үүссэн;
11. Байлдааны зэвсэг хэрэглэх, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;
12. Хохирол учирсан талаар эрх бүхий байгууллага даатгагчид нэн дариу мэдэгдэн шалгуулаагүй болон бусад шалтгаанаар даатгалын зүйлд хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, нотлогдохгүй, тодорхой бус байх;
13. Нөхөн төлбөрийн баримтуудыг хүлээлгэж өгөх, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн хүлээлгийн хугацаа дуусгавар болсноос хойш нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн;
14. Орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгалын хувьд сайн дураар төлсөн болон хүлээн зөвшөөрсөн төлбөр, хохирол, төрийн байгууллагаас ногдуулсан торгууль, шийтгэвэр;
15. Согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсний улмаас учирсан хохирол, гэмт хэргийн шинж чанартай аливаа хохирол;
16. Даатгуулагч гал, эрчим хүч, ус, дулаан, цахилгаан, сантехник ашиглалт, аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, ашиглах дүрэм, заавар, стандартыг шууд ноцтой зөрчсөнөөс үүссэн хохирол,
17. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.